



СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2026 оны 03 сарын 18 өдөр

Дугаар А/111

Улаанбаатар хот

Г “Хоггүй орчин бүрдүүлцгээ” нэг сарын аян Г
зохион байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.1, 62.1.5 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1, Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4, 9.5.2, 10 дугаар зүйлийн 10.2.10 дахь заалт, Хөдөлмөрийн тухай хуулийн 109 дүгээр зүйлийн 109.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 32/03 дугаар тогтоол, Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн 2026 оны А/02 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дүүргийн нутаг дэвсгэрийн хэмжээнд “Хоггүй орчин бүрдүүлцгээ” бүх нийтийн цэвэрлэгээний ажлыг 2026 оны 03 дугаар сарын 16-ны өдрөөс 04 дүгээр сарын 15-ны өдөр хүртэл 1 сарын хугацаанд зохион байгуулсугай.


2. Бүх нийтийн их цэвэрлэгээнд хяналт тавих ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг 1 дүгээр, цэвэрлэгээ зохион байгуулах төлөвлөгөөг 2 дугаар, хамтран оролцох байгууллага, тэдгээрийн хүлээх үүргийг 3 дугаар, хяналт тавих, хамтран оролцох хэлтэс, тасгуудын хуваарийг 4 дүгээр, шаардагдах шатахууны зардлын тооцоог 5 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Хог хаягдлын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж, их цэвэрлэгээний ажилд аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийг өргөнөөр татан оролцуулахыг хороодын Засаг дарга нарт, цэвэрлэгээнээс гарсан хог хаягдлыг шуурхай ачиж тээвэрлэх ажлыг зохион байгуулахыг “Тохижилт, цэвэрлэгээ, үйлчилгээ” ОНӨААТҮГ (О.Буянгэрэл)-т, “Охь мандал” ХХК (Б.Жавзан)-д, “Улаанбаатар шинэчлэл” ХХК (М.Түвдэндорж)-д, “Аливаагоулд” ХХК (Б.Алтаншагай)-д, “Экоплас лайф ХХК (Б.Халиунаа)-д, “Мэйжик Тайм” ХХК (А.Даваахүү)-д, “Эко эрин тохижилт” ХХК (Н.Лхагвасүрэн)-д, “Хүннү билэг” ХХК (Ц.Бадрах)-д, их цэвэрлэгээний ажилд иргэдийг оролцуулах, уриалга гарган нийтэд түгээх ажлыг хариуцан хэрэгжүүлэхийг Агаарын бохирдолтой тэмцэх тасаг (Ц.Гэрэлмаа)-т тус тус үүрэг болгосугай.

4. Их цэвэрлэгээ зохион байгуулахад шаардагдах 400,000 (Дөрвөн зуун мянга) төгрөгийг Хот тохижуулах зардлаас санхүүжүүлэхийг Засаг даргын Тамгын газар (Ж.Бат-Эрдэнэ)-т зөвшөөрсүгэй.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг дүүргийн Менежер (Д.Баярсайхан)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА




Ц.БАТТӨР

E:\2026\Засаг дарга\Захирамж.docx

1826010441

Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын
2026 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн
111 дугаар захирамжийн 1 дүгээр хавсралт



АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн дарга:	С.Нямдорж	Хотын стандарт, тохижилт нийтийн аж ахуйн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч
Гишүүд:	А.Бямба	Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга
	Б.Сугар	Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч
	Т.Баярмаа	Нийгмийн хөгжлийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч
	С.Номингэрэл	Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах төвийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч
	Ц.Гэрэлмаа	Агаарын бохирдолтой тэмцэх тасгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч
Нарийн бичгийн дарга:		Хороодын Засаг дарга нар
	Ц.Чимэдбалдир	Агаарын бохирдолтой тэмцэх тасгийн мэргэжилтэн

Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын
2026 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн
111 дугаар захирамжийн 2 дугаар хавсралт

АЯН ЗОХИОН БАЙГУУЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

9023100756
9091904 + CST23271

№	Хийгдэх ажил	Хугацаа	Хариуцах албан тушаалтан
1	Гудамж, зам талбай, голын ай сав газар, төмөр замын хамгаалалтын зурвас газрын хог хаягдлыг цэвэрлэх, айл өрх аж ахуйн нэгж байгууллагуудын хог хаягдлын ачилт, тээвэрлэлтийн ажлыг эрчимжүүлэх	03 дугаар сарын 21, 22, 28, 29-ний өдрүүд 04 дүгээр сарын 4, 5, 11, 12-ны өдрүүдэд	Агаарын бохирдолтой тэмцэх тасаг, Хог тээврийн байгууллагууд
2	Нийтийн эзэмшлийн гудамж, зам талбайд байршуулсан өнгө үзэмжгүй хаяг, мэдээллийн байгууламжийг буулгах	03 дугаар сарын 21, 22, 28, 29- ний өдрүүд 04 дүгээр сарын 4, 5, 11, 12-ны өдрүүдэд	Хотын стандарт, тохижилт нийтийн аж ахуйн хэлтэс
3	Сууц өмчлөгчдийн холбоодыг их цэвэрлэгээний ажилд татан оролцуулах, хүүхдийн тоглоомын талбайн угаалга цэвэрлэгээг хийлгэх	03 дугаар сарын 21, 22, 28, 29- ний өдрүүд 04 дүгээр сарын 4, 5, 11, 12-ны өдрүүдэд	Хотын стандарт, тохижилт нийтийн аж ахуйн хэлтэс
4	Автобусны буудал, тоглоомын талбай, хайс хашлага, цэцгийн мандал, хогийн сав, хөшөө дурсгалын цэвэрлэгээ хийх, үерийн далан сувгийн хог хаягдлыг цэвэрлэх	03 дугаар сарын 21, 22, 28, 29- ний өдрүүд 04 дүгээр сарын 4, 5, 11, 12-ны өдрүүдэд	Нийтийн эзэмшлийн зам талбайн цэвэрлэгээний байгууллагууд
6	Аж ахуйн нэгж, байгууллагуудын гадна хаяг, хаягийн байгууламжийн өнгө үзэмжийг сэргээх, угаалгах	03 дугаар сарын 21, 22, 28, 29- ний өдрүүд 04 дүгээр сарын 4, 5, 11, 12-ны өдрүүдэд	Хүнс худалдаа үйлчилгээний хэлтэс
7	Их, дээд сургууль болон ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн гадна орчныг угааж цэвэрлэх	03 дугаар сарын 21, 22, 28, 29- ний өдрүүд 04 дүгээр сарын 4, 5, 11, 12-ны өдрүүдэд	Нийгмийн хөгжлийн хэлтэс
8	Нийтийн эзэмшлийн гэрэлтүүлгийн шонг засварлах, шатсан гэрлүүдийг солих, шон дээр наасан зарлал наалтыг хуулах, ил задгай утсыг далдлах, шонг угаах	03 дугаар сарын 21, 22, 28, 29- ний өдрүүд 04 дүгээр сарын 4, 5, 11, 12-ны өдрүүдэд	Хотын стандарт, тохижилт нийтийн аж ахуйн хэлтэс
9	Хийгдэж байгаа ажлын явцын талаар хэвлэл, мэдээллийн хэрэгслээр иргэд, айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагуудыг сурталчлах	03 дугаар сарын 21, 22, 28, 29- ний өдрүүд 04 дүгээр сарын 4, 5, 11, 12-ны өдрүүдэд	Хороодын Засаг дарга нар, Хэвлэл мэдээлэл олон нийттэй харилцах төв
10	Хийсэн ажлын мэдээг нэгтгэн Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албанд хүргүүлэх	03 дугаар сарын 21, 22, 28, 29- ний өдрүүд 04 дүгээр сарын 4, 5, 11, 12-ны өдрүүдэд	Агаарын бохирдолтой тэмцэх тасаг

Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын
2026 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн
А/Н дугаар захирамжийн 3 дугаар хавсралт

**ХАМТРАН ОРОЛЦОХ БАЙГУУЛЛАГА,
ТЭДГЭЭРИЙН ХҮЛЭЭХ ҮҮРЭГ**

9023100756 1
9091304 А СБТ23271

Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын Тамгын газар, хэлтэс, хороодын Засаг дарга нар, хог хаягдлын үйлчилгээний байгууллагууд, Замын цэвэрлэгээ үйлчилгээ, Гэрэлтүүлэг, Ногоон байгууламжийн арчилгаа хамгаалалт хариуцсан байгууллагууд, аж ахуйн нэгжүүд, хороодын Хог хаягдал олон нийтийн байцаагчид, хэсгийн ахлагч нар, ард иргэд оролцоно.

№	Байгууллага	Хариуцах ажил
1	Хотын стандарт, тохижилт, нийтийн аж ахуйн хэлтэс	Сууц өмчлөгчдийн холбоод, Гэрэлтүүлэг, Ногоон байгууламж хариуцсан байгууллагуудыг цэвэрлэгээний ажилд оролцуулж, мэдээ тайланг Агаарын бохирдолтой тэмцэх тасагт ирүүлэх
2	Цэргийн штаб	Цэргийн ангиудыг их цэвэрлэгээний ажилд татан оролцуулж, хороодын нутаг дэвсгэрт үүссэн хог хаягдлын цэвэрлэгээ нийтийн эзэмшлийн явган зам дагуу түүвэр хог хаягдлыг цэвэрлэх ажлыг зохион байгуулах
3	Агаарын бохирдолтой тэмцэх тасаг	Бүх хороодод хяналт тавьж нэгдсэн удирдлагаар хангах. Цэвэрлэгээний ажлыг зохион байгуулах, оролцогч байгууллагуудын ажлын уялдаа холбоог хангах, цэвэрлэгээний дүн мэдээг нэгтгэж, дүүргийн удирдлагуудад танилцуулах
4	Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах төв	Цэвэрлэгээ зохион байгуулагдах талаар хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлэх, цэвэрлэгээний ажлын явц үр дүнгийн талаар ТВ, радиогоор олон нийтэд хүргэх, хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлах
5	Хороод	Тухайн нутаг дэвсгэрийнхээ иргэд, байгууллага, аж ахуйн нэгжүүдэд цэвэрлэгээний талаар мэдээлэл хүргэх, хаяг, хаягийн байгууламж, хаалга, цонх, хайс, хашааг угаалгах, цэвэрлэх, хог хаягдлын цэвэрлэгээний ажилд өргөнөөр хамруулах, цэвэрлэж бөөгнүүлсэн, хог хаягдлыг түргэн шуурхай ачуулах, хог хаягдлыг шатаахгүй байх тал дээр онцгой анхаарч Хог хаягдлын олон нийтийн байцаагч нартай хамтран цэвэрлэгээний ажилд тогтмол хяналт тавьж ажиллах, тайлан мэдээг Агаарын бохирдолтой тэмцэх тасагт ирүүлэх
6	Хог хаягдлын үйлчилгээний байгууллагууд	Хариуцсан хороодын нутаг дэвсгэрт их цэвэрлэгээний ажлыг зохион байгуулах, цэвэрлэгээнээс гарсан хог хаягдлыг шуурхай ачиж тээвэрлэх
7	Зам цэвэрлэгээ, гэрэлтүүлэг, ногоон байгууламж хариуцсан байгууллагууд	Хариуцсан нийтийн эзэмшлийн зам талбай, автобусны буудал, тоглоомын талбай, сандал, хөшөө дурсгал, цэцгийн мандал, хайс, хашлага, замын тэмдэг, хогийн сав, гэрлийн шонг угаах, хог хаягдлыг цэвэрлэх ажлыг зохион байгуулах

8	Сууц холбоод	өмчлөгчдийн	Хариуцсан байрнуудын гадна орчин, нийтийн эзэмшлийн талбай, орчны цэвэрлэгээг хийж, тоглоомын талбай, хайс хашлага, замын тэмдэг, хогийн савыг угаалгах, хог хаягдлыг цэвэрлэх мэдээ тайланг хорооны Засаг даргын ажлын албанд хүргүүлэх СӨХ хариуцсан мэргэжилтэнд хүргүүлэх.
9	Аж ахуйн тасаг		Дүүргийн Засаг даргын Тамгын газрын 1, 2, 3 дугаар байрны гадна орчны 50 метр хүртэлх талбай, авто зогсоолын хог хаягдал, хайс, хашааг цэвэрлэх, угаах ажлыг зохион байгуулах 9023100756 9091904 = СБТ23271
10	Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын хэлтэс		36 дугаар хорооны нутаг алтан овооны нийтийн эзэмшлийн зам талбай, явган зам, хананаас хана хүртэлх талбайн хог хаягдлыг цэвэрлэх
11	Нийгмийн газар	даатгалын	Миний дэлгүүрийн уулзвараас 62 дугаар сургууль хүртэлх авто зам дагуух хог хаягдлыг цэвэрлэх, байгууллагын гадна орчны 50 метр хүртэлх талбайн хог хаягдал байгууллагын гадна хаяг, хаягийн байгууламжийг угаах ажлыг зохион байгуулах
12	Татварын хэлтэс		Лабораторийн автобусны буудлаас Депогийн автобусны буудал хүртэлх явган замын түүвэр хог хаягдал, байгууллагын гадна орчны 50 метр хүртэлх талбайн хог хаягдал, байгууллагын гадна хаяг, хаягийн байгууламж, хайс, хашааг угаах ажлыг зохион байгуулах
13	Цагдаагийн 1 дүгээр хэлтэс		Далангийн авто замын 2 талын явган замын хананаас хана хүртэлх талбайн хог хаягдлыг цэвэрлэх, байгууллагын гадна хаяг, хаягийн байгууламж, хайс, хашааг угаах ажлыг зохион байгуулах
14	Дүүргийн Улаан загалмайн хороо		
15	Сонгинохайрхан дүүргийн Насан туршийн суралцахуйн төв		
16	Цагдаагийн 2 дугаар хэлтэс		Баянхошууны шинэ эцсээс Жанцангийн уулзвар хүртэлх нийтийн эзэмшлийн авто замын дагуу хог хаягдал, байгууллагын гадна орчны 50 метр хүртэлх талбайн хог хаягдал, байгууллагын гадна хаяг, хаягийн байгууламж, хайс, хашааг цэвэрлэх, угаах ажлыг зохион байгуулах
17	Цагдаагийн 3 дугаар хэлтэс		Барилгачдын гудамжны нийтийн эзэмшлийн авто зам дагуу хог хаягдал, байгууллагын гадна орчны 50 метр хүртэлх талбайн хог хаягдал, хөл газрыг ургамлыг цэвэрлэх, байгууллагын гадна хаяг, хаягийн байгууламж, хайс, хашааг цэвэрлэх, угаах ажлыг зохион байгуулах
18	Улсын бүртгэлийн хэлтэс		Дүүргийн Засаг даргын Тамгын газрын байрны зүүн талаас төв зам хүртэлх нийтийн эзэмшлийн авто зам дагуух хог хаягдлыг цэвэрлэх
19	Дүүргийн Газар зохион байгуулалтын алба		8 дугаар хороо, 67 сургуулийн уулзвараас Баянхошууны төв зам хүртэлх нийтийн эзэмшлийн авто замын 2 талын явган замын хананаас хана хүртэлх талбайн хог хаягдлыг цэвэрлэх
20	Статистикийн хэлтэс		Дүүргийн Засаг даргын Тамгын газрын арын нийтийн эзэмшлийн авто зам дагуу хог хаягдлыг цэвэрлэх
21	"Захиалагчийн алба" ОНӨААТҮГ		42 дугаар хороо, Зүүн салааны автобусны эцсийн буудлаас Богины ам, Ухны амын уулзвар хүртэлх

22	Худалдан авах ажиллагааны алба	нийтийн эзэмшлийн авто замын 2 талын явган замын хананаас хана хүртэлх талбайн хог хаягдлыг цэвэрлэх
23	Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар	24 дүгээр хороо, баруун салааны шинэ эцсээс Бумбатын рашаан хүртэлх нийтийн эзэмшлийн авто замын 2 талын явган замын хананаас хана хүртэлх талбайн хог хаягдлыг цэвэрлэх, хүүхдийн тоглоомын талбайн угаалга хийх
24	Биеийн тамир спортын хороо	БТСХорооны байрнаас төв зам хүртэлх нийтийн эзэмшлийн авто зам дагуух хог хаягдал, байгууллагын гадна орчны 50 метр хүртэлх талбайн хог хаягдал хөл газрын ургамлыг цэвэрлэх, байгууллагын гадна хаяг, хаягийн байгууламж, хайс, хашааны угаалга, цэвэрлэгээг зохион байгуулах
25	Дотоод аудитын алба	Далангийн замаас 41 дүгээр хороо, 124 дүгээр сургууль, Баруун салааны зам хүртэлх нийтийн эзэмшлийн авто замын 2 талын явган замын хананаас хана хүртэлх талбайн хог хаягдлыг цэвэрлэх
26	Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих мэдээлэл сургалтын төв	
27	Спорт цогцолбор УТҮГ	Байгууллагын гадна орчны 50 метр хүртэлх талбайн хог хаягдал, байгууллагын гадна хаяг, хаягийн байгууламж, хайс, хашааны угаалга цэвэрлэгээг зохион байгуулах, Толгойтын автозамаас гэмтлийн эмнэлэг хүртэлх 6 эгнээ авто замын 2 талын явган замын хананаас хана хүртэлх талбайн хог хаягдлыг цэвэрлэх
28	Теле камерийн хяналтын дэд төв	
29	Боловсролын хэлтэс	Дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхлэн явуулж байгаа боловсролын байгууллагуудыг цэвэрлэгээнд татан оролцуулж, мэдээг нэгтгэн Агаарын бохирдолтой тэмцэх тасагт хүргүүлэх.
30	Сонгинохайрхан дүүргийн Эрүүл мэндийн төв	Залуус гудамжны нийтийн эзэмшлийн авто зам дагуу хог хаягдал, байгууллагын гадна орчны 50 метр хүртэлх талбайн хог хаягдал, цас, мөс, байгууллагын гадна хаяг, хаягийн байгууламж, хайс, хашааны цэвэрлэгээг зохион байгуулах
31	Дүүргийн байдлын хэлтэс	Онцгой
32	Дүүргийн эмнэлэг	Нэгдсэн

Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын
2026 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн
АМН дугаар захирамжийн 4 дүгээр хавсралт

АЯНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХЯНАЛТ ТАВИХ
ХЭЛТЭС, ТАСГУУДЫН ХУВААРЬ

9023100756
9091904 & СБТ23271

№	Байгууллага	Хариуцах ажил
1	Дүүргийн Менежер, Хяналт шинжилгээ үнэлгээний хэлтэс	Ерөнхий хяналт
2	Хотын стандарт, тохижилт, нийтийн аж ахуйн хэлтэс	Дүүргийн 27, 29 дүгээр хорооны нутаг дэвсгэрт үүссэн хог хаягдлын цэвэрлэгээ нийтийн эзэмшлийн явган зам дагуу түүвэр хог хаягдлыг цэвэрлэх, ажлыг зохион байгуулах, байгууллагын гадна хаяг, хаягийн байгууламж, хайс, хашааг угааж, чийгтэй цэвэрлэгээг хийлгэхэд хамтран оролцох, мэдээ тайланг Агаарын бохирдолтой тэмцэх тасагт ирүүлэх
3	Цэргийн штаб	Дүүргийн 20 дугаар хорооны нутаг дэвсгэрт үүссэн хог хаягдлын цэвэрлэгээ нийтийн эзэмшлийн явган зам дагуу түүвэр хог хаягдлыг цэвэрлэх, ажлыг зохион байгуулах, байгууллагын гадна хаяг, хаягийн байгууламж, хайс, хашааг угааж, чийгтэй цэвэрлэгээг хийлгэхэд хамтран оролцох, мэдээ тайланг Агаарын бохирдолтой тэмцэх тасагт ирүүлэх
4	Агаарын бохирдолтой тэмцэх тасаг	Оролцогч байгууллагуудын ажлын уялдаа холбоог хангах, цэвэрлэгээний дүн мэдээг нэгтгэж, нийслэл, дүүргийн удирдлагуудад танилцуулах, мэдээг Улаанбаатар хотын Шуурхай удирдлага зохицуулалтын төв, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албанд хүргүүлэх
5	Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах төв	Цэвэрлэгээний талаар хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлэх, цэвэрлэгээний ажлын явц үр дүнгийн талаар ТВ, радиогоор олон нийтэд хүргэх, хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлах
6	Аж ахуйн тасаг	Дүүргийн Засаг даргын Тамгын газрын шинэ, хуучин байрны гадна орчны 50 метр хүртэлх талбай, хайс хашаа, цэцгийн мандал, хөшөө дурсгалыг угаах, хог хаягдлыг цэвэрлэх ажлыг зохион байгуулах
7	Хүнс худалдаа үйлчилгээний хэлтэс	Дүүргийн 6, 37 дугаар хорооны нутаг дэвсгэрт үүссэн хог хаягдлын цэвэрлэгээ нийтийн эзэмшлийн явган зам дагуу түүвэр хог хаягдлыг цэвэрлэх, ажлыг зохион байгуулах, байгууллагын гадна хаяг, хаягийн байгууламж, хайс, хашааг угааж, чийгтэй цэвэрлэгээг хийлгэх ажилд хамтран оролцох, мэдээ тайланг Агаарын бохирдолтой тэмцэх тасагт ирүүлэх
8	Нийгмийн хөгжлийн хэлтэс	Дүүргийн 12 дугаар хорооны нутаг дэвсгэрт үүссэн хог хаягдлын цэвэрлэгээ нийтийн эзэмшлийн явган зам дагуу түүвэр хог хаягдлыг цэвэрлэх, ажлыг зохион байгуулах, байгууллагын гадна хаяг, хаягийн байгууламж, хайс, хашааг угааж, чийгтэй цэвэрлэгээг хийлгэхэд хамтран оролцох, мэдээ тайланг Агаарын бохирдолтой тэмцэх тасагт ирүүлэх

9	Төрийн захиргаа удирдлагын хэлтэс	Дүүргийн 13 дугаар хорооны нутаг дэвсгэрт үүссэн хог хаягдлын цэвэрлэгээ нийтийн эзэмшлийн явган зам дагуу түүвэр хог хаягдлыг цэвэрлэх, ажлыг зохион байгуулах, байгууллагын гадна хаяг, хаягийн байгууламж, хайс, хашааг угааж, чийгтэй цэвэрлэгээг хийлгэхэд хамтран оролцох, мэдээ тайланг Агаарын бохирдолтой тэмцэх тасагт ирүүлэх
10	Хууль эрх зүйн хэлтэс	Дүүргийн 14 дүгээр хорооны нутаг дэвсгэрт үүссэн хог хаягдлын цэвэрлэгээ нийтийн эзэмшлийн явган зам дагуу түүвэр хог хаягдлыг цэвэрлэх, ажлыг зохион байгуулах, байгууллагын гадна хаяг, хаягийн байгууламж, хайс, хашааг угааж, чийгтэй цэвэрлэгээг хийлгэхэд хамтран оролцох, мэдээ тайланг Агаарын бохирдолтой тэмцэх тасагт ирүүлэх
11	Санхүү төрийн сангийн хэлтэс	Дүүргийн 15 дугаар хорооны нутаг дэвсгэрт үүссэн хог хаягдлын цэвэрлэгээ нийтийн эзэмшлийн явган зам дагуу түүвэр хог хаягдлыг цэвэрлэх, ажлыг зохион байгуулах, байгууллагын гадна хаяг, хаягийн байгууламж, хайс, хашааг угааж, чийгтэй цэвэрлэгээг хийлгэхэд хамтран оролцох, мэдээ тайланг Агаарын бохирдолтой тэмцэх тасагт ирүүлэх
12	Төлөвлөлт гүйцэтгэлийн удирдлагын хэлтэс	Дүүргийн 16 дугаар хорооны нутаг дэвсгэрт үүссэн хог хаягдлын цэвэрлэгээ нийтийн эзэмшлийн явган зам дагуу түүвэр хог хаягдлыг цэвэрлэх, ажлыг зохион байгуулах, байгууллагын гадна хаяг, хаягийн байгууламж, хайс, хашааг угааж, чийгтэй цэвэрлэгээг хийлгэхэд хамтран оролцох, мэдээ тайланг Агаарын бохирдолтой тэмцэх тасагт ирүүлэх
13	Санхүүгийн тасаг	Дүүргийн 17 дугаар хорооны нутаг дэвсгэрт үүссэн хог хаягдлын цэвэрлэгээ нийтийн эзэмшлийн явган зам дагуу түүвэр хог хаягдлыг цэвэрлэх, ажлыг зохион байгуулах, байгууллагын гадна хаяг, хаягийн байгууламж, хайс, хашааг угааж, чийгтэй цэвэрлэгээг хийлгэхэд хамтран оролцох, мэдээ тайланг Агаарын бохирдолтой тэмцэх тасагт ирүүлэх
14	Архивын хэлтэс	Дүүргийн 18 дүгээр хорооны нутаг дэвсгэрт үүссэн хог хаягдлын цэвэрлэгээ нийтийн эзэмшлийн явган зам дагуу түүвэр хог хаягдлыг цэвэрлэх, ажлыг зохион байгуулах, байгууллагын гадна хаяг, хаягийн байгууламж, хайс, хашааг угааж, чийгтэй цэвэрлэгээг хийлгэхэд хамтран оролцох, мэдээ тайланг Агаарын бохирдолтой тэмцэх тасагт ирүүлэх
15	Хөдөө аж ахуйн тасаг	Дүүргийн 19 дүгээр хорооны нутаг дэвсгэрт үүссэн хог хаягдлын цэвэрлэгээ нийтийн эзэмшлийн явган зам дагуу түүвэр хог хаягдлыг цэвэрлэх, ажлыг зохион байгуулах, байгууллагын гадна хаяг, хаягийн байгууламж, хайс, хашааг угааж, чийгтэй цэвэрлэгээг хийлгэхэд хамтран оролцох, мэдээ тайланг Агаарын бохирдолтой тэмцэх тасагт ирүүлэх

Дүүргийн хэлтэс, тасгууд, 2026 оны 03 дугаар сарын 28, 29-нд хариуцсан хорооны бүх нийтийн их цэвэрлэгээнд хамтран оролцож, бусад өдрүүдэд хяналтын үүрэг гүйцэтгэнэ.

Бүх нийтийн их цэвэрлэгээг зохион байгуулсан нэгдсэн мэдээ тайланг 2026 оны 03 дугаар сарын 22,29-ний өдөр, 4 дүгээр сарын 05,12-ны өдрүүдэд цахимаар, 4

дүгээр сарын 15-ны өдөр нэгдсэн тайланг 15:00 цагаас өмнө цаасаар дүүргийн
Агаарын бохирдолтой тэмцэх тасагт ирүүлэх:

Мэргэжилтэн Ц.Чимэдбалдир холбогдох утас: 96010207

цахим хаяг: ts.baldir12@gmail.com

Хог хаягдлын үйлчилгээний байгууллагуудтай холбогдох утас:

“Тохижилт, цэвэрлэгээ, үйлчилгээ” ОНӨААТҮГ-ын захирал О.Буянгэрэл

Утас: 99034539

“Улаанбаатар шинэчлэл” ХХК-ний захирал М.Түвдэндорж Утас: 99080486

“Охь мандал” ХХК-ний захирал Б.Жавзан Утас: 99040988


“Аливаа гоулд” ХХК-ний захирал Б.Алтанүгай Утас: 88055566

“Экоплас лайф” ХХК-ний захирал Б.Халиунаа Утас: 88881407

“Хүннү билэг” ХХК-ний захирал Ц.Бадрах Утас: 99074553

“Эко эрин” ХХК-ний захирал Н.Лхагвасүрэн Утас: 95005596

“Мейжик тайм” ХХК захирал А.Даваахүү Утас: 89486849



Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын
2026 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн
А/А дугаар захирамжийн 5 дугаар хавсралт

ШАТАХУУНЫ ЗАРДЛЫН ТООЦОО

№	Хэлтэс, албадын нэр	Зардал	Олгох шатахууны хэмжээ (төгрөг)	Зориулалт
1	Хяналт, шинжилгээ, үнэлгээний хэлтэс	8 өдөр	100,000	Ерөнхий хяналт
2	Агаарын бохирдолтой тэмцэх тасаг	8 өдөр	100,000	Бүх хороодоор хяналт тавьж ажиллах унааны зардал
3	Хүнс худалдаа үйлчилгээний хэлтэс	8 өдөр	100,000	Дүүргийн 43 хороонд үйл ажиллагаа эрхлэн явуулж буй аж ахуйн нэгж байгууллагууд, их цэвэрлэгээний ажилд хяналт тавих
4	Хотын стандарт, тохижилт нийтийн аж ахуйн хэлтэс	8 өдөр	100,000	Бүх хороодын СӨХ, Ногоон байгууламж, Гэрэлтүүлгийн комданиудын цэвэрлэгээнд хяналт тавьж ажиллах унааны зардал
ДҮН			400,000	